



МОНГОЛ УЛС  
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН  
ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 27-өдөр

Дугаар 1165

Есөнбулаг

Гамшигаас хамгаалах өндөржүүлсэн

бэлэн байдлын зэрэгт

шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.13 дахь хэсэг, 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Гамшигаас хамгаалах тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4, 32 дугаар зүйлийн 32.1.1 дэх хэсэг, Засгийн газрын 2024 оны 62 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Өвөлжилт, хаваржилтыг даван туулах, цаг агаарын аюулт болон гамшигт үзэгдлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, хариу арга хэмжээг шуурхай зохион байгуулах зорилгоор 02 дугаар сарын 15-ны өдрөөс 05 дугаар сарын 15-ны өдөр хүртэл хугацаанд аймгийн хэмжээнд гамшигаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсүгэй.

2.Гамшигаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан зудын гамшигийн эрсдэлийг хохирол багатай даван туулах зорилгоор аймаг, сумдын Онцгой комиссын шуурхай штабын үйл ажиллагааг идэвхжүүлэх, гамшигаас хамгаалах алба, мэргэжлийн ангийн харилцан ажиллагаа, бэлтгэл, бэлэн байдлыг хангуулж ажиллахыг Онцгой байдлын газар (дэд хурандаа Ц.Лувсанжамц), сумдын Засаг дарга, Онцгой комиссын дарга нарт;

3.Аймаг, сумын шатахуун түвш, яаралтай түргэн тусламжийн эм, эмнэлгийн хэрэгсэл, хүнсний бүтээгдэхүүний неөцийг 70 хувиас доошгүй байхаар нөхөн бүрдүүлэлт хийж бэлэн байдлыг хангаж ажиллахыг Хүнс, хөдөө аж ахуйн газар (Т.Сүхбаатар), Эрүүл мэндийн газар (Г.Лхагважаргал), сумын Засаг дарга, Онцгой комиссын дарга нарт;

4.Бусад аймаг, сумдын нутаг дэвсгэрт отор нүүдэл хийж байгаа малчдад териин бүх төрлийн үйлчилгээг чанар, хүртээмжтэй хүргэж ажиллахыг Эрүүл мэндийн газар (Г.Лхагважаргал), Боловсрол, шинжлэх ухааны газар (Ж.Амгаланбаатар), Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын газар

(Б.Алтайбаатар), сумын Засаг дарга, Онцгой комиссын дарга нарт;


5.Мал, амьтны гоц халдварт өвчний голомтот бус нутгуудад отор нүүдэл хийж байгаа малчдын малын шилжилт хөдөлгөөнд тавих, хяналтыг эрчимжүүлж ажиллахыг Мал эмнэлгийн газар(Р.Бүрэнбаясах)-т;

6.Цахилгаан эрчим хүчний гэнэтийн аваар саатал гарсан үед 1, 2 зэрэглэлийн хэрэглэгч нарыг цахилгаан эрчим хүчээр хангаж, аваар саатлыг богино хугацаанд арилгаж, хэвийн горимд оруулж ажиллахыг "Алтай-Улиастайн зрчим хүчний систем" ТӨХК(Б.Цэдэвсүрэн)-д;

7.Байгаль, цаг агаарын гаралтай аюулт үзэгдэл, ослын улмаас автозам, даваа хаагдсан тохиолдолд холбогдох аж ахуйн нэгжүүдийг ажиллуулж, зорчигч, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнийг хэвийн явуулах нөхцөл боломжийг бүрдүүлж ажиллахыг Автотээврийн төв (С.Гантулга), "Говь-Алтай-АЗЗА" ТӨХК (Б.Алтанхуяг) дарга, захирал нарт;

8.Аймгийн хэмжээнд цаг агаарын урьдчилан сэргийлэх, сээрэмжлүүлэг мэдээ, мэдээлэл, цасны хэмжилтийн мэдээг аймаг, сумдын Онцгой комиссын Шуурхай штаб, гишүүд болон малчид, иргэдэд тухай бүр шуурхай хүргэж ажиллахыг Ус, цаг уур орчны шинжилгээний төв(Н.Алтантуяа)-д тус тус үүрэг болгосугай.

9.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Г.Чинбат)-д даалгасугай.





- ۶ .. «گلپیشتر یا گلدم روکنم و رکننم دارم بده»، پستچی یا سخنسرم بده) فو ۶ + از شرایطی که نکنید کن نهاد گلپیشتر  
یا گلدم رکن و برسنندو ، بدهم) بظنه د و متفقند و متفقند هستند فو بگذشتندو ، نو مر یا گلدم فو بگذشتندو بگذشتندو در «بدهم  
بگذشتند دارم یا گلدم و بگذارم») چندو دارم بظنه دارم یا مفهومشندو بگذارم (و . چندیم و بگذارم) فو
- ۷ .. و متفقند ، حکم یا نظر فو یا سخنی دارم بگذشتندو بگذشتندو ، بگذشتندو بگذشتندو بگذشتندو بگذشتندو  
بگذشتندو بگذشتندو بگذشتندو بگذشتندو بگذشتندو بگذشتندو بگذشتندو بگذشتندو بگذشتندو بگذشتندو بگذشتندو  
بگذشتندو بگذشتندو بگذشتندو بگذشتندو بگذشتندو بگذشتندو بگذشتندو بگذشتندو بگذشتندو بگذشتندو بگذشتندو بگذشتندو  
بگذشتندو بگذشتندو بگذشتندو بگذشتندو بگذشتندو بگذشتندو بگذشتندو بگذشتندو بگذشتندو بگذشتندو بگذشتندو بگذشتندو
- ۸ .. «گلپیشتر دارم را گذارم فو را بگفرم چیزی که بگذشتندو در گلپیشتر دارم گذارم (و . چندیم و بگذارم) دارم گذارم (و . چندیم و بگذارم) فو  
گذشتندو بگذشتندو ..

